

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖИЙН  
12 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТ**

2020 оны 01 дүгээр сарын 03

Багануур дүүрэг

№	Ирсэн огноо	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт
1	2019.06.28	2019.06.21	А/619	<p>Паркийн “Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв”-ийн барилгын зураг төслийг Нутаг Консалт ХХК боловсруулж байна. Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газраас архитектур төлөвлөлтийн даалгаврыг баталж, нэршлийг “Үйлдвэрийн албан контор”-ын барилга болгон өөрчилсөн. Паркийн зүгээс байршлыг тодорхойлох, холбогдох бичиг баримтуудыг гаргах, хангагч байгууллагуудаас техникийн нөхцөл гаргуулах ажилд оролцож, гүйцэтгэлд хяналт тавьж байна. Барилгын ажлын зураг холбооны техникийн нөхцөл авах ажлаас хамаарч ондоо багтаан гүйцэтгэх боломжгүй болсон.</p>
2	2019.06.28	2019.06.21	А/619	<p>Багануур үйлдвэрлэл, технологийн парк төслийн “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ”-г гүйцэтгүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ын дагуу БОННУ-ний тайланг 2019.12.04-ний өдөр 5 хороодын Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэхэд олонхын саналаар тайланд “ХАНГАЛТТАЙ” гэсэн дүгнэлт өгч паркийн үйл ажиллагааг дэмжих нь зүйтэй гэж үзсэн.</li> <li>- Дүүргийн 1, 2, 5 дугаар хорооноос ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, 3, 4 дүгээр хорооноос паркийн төслийг дэмжсэн тухай албан бичгийг гарган 2019.12.10-ны өдөр хүргүүлсэн.</li> <li>- Мөн үнэлгээний тайланд паркийн зүгээс өгөх саналаа Санни трейд ХХК-д уламжилсан.</li> </ul> <p>Гүйцэтгэгч байгууллага нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-аар батлуулахаар хянуулж байна.</p>
3	2019.10.11	2019.10.09	А/1054	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Нийслэлийн мэдээллийн технологийн газраас зохион байгуулсан UB ERP дотоод удирдлагын системийн 2 дугаар шатны сургалтын материалын системээс татаж ашиглан дотооддоо сургалт зохион байгуулав.</p> <p>“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийт 189 бичиг ирснээс хариутай бичиг 72, хариутай бичгийн шийдвэрлэлт 94.29%, хариугүй бичгийн хаалт 98.00%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт</p>



94.48%-тай байна.

"Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас 2019 оны 12 сарын 27-ны өдрийн байдлаар яам, нийслэл, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад нийт 248 албан бичиг явуулсан байна.

Баримт бичгийн шийдвэрлэлтийг графикаар харуулав.

№	Үзүүлэлтүүд	Улирлын мэдээ/хувиар/				
		I	II	III	IV	Нийт
1	Нийт ирсэн бичгийн тоо	24	52	36	77	189
2	Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт	97.69	95.22	90.06	94.60	94.49
3	Хариутай бичгийн шийдвэрлэлт	100	95.24	89.29	92.50	94.29
4	Хариугүй бичгийн хаалт	88.46	95.16	93.18	98.00	98.00
5	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	8.58	15.48	12.67	5.00	9.83
6	Зөрчилтэй албан бичиг	0	1	3	0	4

- Байгууллагын нэр андуурч илгээсэн зөрчил 4 байна. Зөрчлийн дэлгэрэнгүй мэдээг ашиглан зөрчил гаргахгүй байхад анхаарч ажилласны үр дүнд 2019 оны 04 дүгээр улиралд өмнө гаргасан зөрчил давтагдаагүй.
- Бүртгэл хяналтын картыг 2019 оноос эхлэн хариутай бичигт хөтлөн ажилласан.

4	2019.12.18	2019.12.13	A/1309	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны балансаас Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 175 000 000 /нэг зуун далан таван сая/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үйлдвэрлэл, технологийн паркийн барилга байгууламжийг нийслэлийн өмчид шилжүүлж Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн данс бүртгэлд бүртгэн, ашиглалт, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг үүрэг болгосон. Иймд Паркийн даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/38 дугаар тушаалаар барилга байгууламжийг бүртгэн авч, байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлд ашиглалт, хамгаалалтыг хариуцуулав.
5	2019.12.23	2019.12.20	A/1340	БҮТП нь "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт"-ийн Улсын үзлэгээр 95 А үнэлгээ авсан.  Улсын үзлэгийн дүнг албан хаагч нарт танилцуулж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан.  Улсын үзлэгийн дүн, зөвлөмжид дүгнэлт хийж, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг холбогдох

			<p>заавар, журмын дагуу хөтлөн явуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ зохион байгуулахаар 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг төсөвт суулгасан.</p> <p>Үзлэгт амжилттай дүгнэгдэж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан албан хаагчдыг Паркийн даргын 2019 оны А/39 дугаар тушаалаар шагнаж урамшуулсан.</p>
--	--	--	---

ХЯНАСАН:

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
ПАРК" ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Т.ЭЛБЭГСАЙХАН



БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МИЧИД-ЭРДЭНЭ